



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 120


Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн гишүүдийг
томилох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 06 сарын 29-ний өдрийн 01/2141 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Удирдах зөвлөлийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТТУЛГА

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны
өдрийн 120 дугаар тогтоолын хавсралт



“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн
парк” ОНӨТҮГ-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Гишүүд:

Т.Бат-Эрдэнэ

Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон
хөгжлийн асуудал хариуцсан орлогч

Б.Энх-Амгалан

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын
Төлөөлөгч

С.Балжинням

Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн
бодлого зохицуулалтын газрын дарга
/зөвшилцсөнөөр/

Ц.Баярмаа

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хүнсний
үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга /зөвшилцсөнөөр/

Г.Пүрэвсүрэн

Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын
дарга

Д.Батжаргал

Хөдөө аж ахуйн биржийн Захиргааны албаны
захирал /зөвшилцсөнөөр/

Т.Баярсайхан

Арьс ширний үйлдвэрлэлийн холбооны
гүйцэтгэх захирал